

20~~25~~ он 05 сар 21 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

**Бизнесийн зээлийн гэрээ байгуулах,
Хөрөнгө үргэлжлүүлэн барьцаалах тухай**

“Говь” ХК нь “Голомт Банк”-тай бизнесийн зээлийн гэрээ байгуулах асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалтыг тус тус удирдлага болгон “Говь” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. “Говь” ХК нь дараах нөхцөлийн дагуу “Голомт Банк”-тай “Бизнесийн зээл”-ийн гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй. Үүнд:
 - 1.1. Зээлийн хэмжээ: 30,000,000,000 /гучин тэрбум/ төгрөг
 - 1.2. Зээлийн хугацаа: 24 /хорин дөрвөн/ сар
 - 1.3. Төгрөгийн зээлийн хүү жилийн: 16.0 /арван зургаан/ хувь, Засгийн газраас хариуцан төлөх зээлийн хүүгийн хөнгөлөлт нь жилийн хувьсах 10.0 /арван/ хувь,
2. Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар “Говь” ХК-ийн Хавсралт №1-д заасан хөрөнгүүдийг үргэлжлүүлэн барьцаалахыг зөвшөөрсүгэй.
3. Дээрх Бизнесийн зээлийн гэрээ, барьцааны гэрээ, батлан даалтын гэрээ болон бусад холбогдох гэрээ, бичиг баримтад “Говь” ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг “Таван Богд Холдингс” ХХК-ийн Санхүү удирдлага хариуцсан захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Оргил/-д олгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:



Ц.БААТАРСАЙХАН

Б.АМАРСАЙХАН

Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Б.ОРГИЛ

Ц.ОРГИЛБОЛД

Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР

Б.ЦЭЭНЯМ